

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/96/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт гүйцэтгэлийн тайлан.....	14
3. АУДИТЫН ТАЙЛАН	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/109
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Л.АЛТАНХУЯГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020362

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,899,694.85</u>	<u>99,506,642.60</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	3,496,588.68
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	3,496,588.68
3121	Төгрөг	00.00	3,496,588.68
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,529,653.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	1,966,935.68
33	АВЛАГА	00.00	51,691,820.00
335	Бусад авлага	00.00	51,691,820.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	51,691,820.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,899,694.85	44,318,233.92
351	Түүхий эд материал	14,768,821.70	23,446,834.40
35110	Тусгай зориулалттай материал	807,855.00	807,855.00
35130	Эм боох материал	13,960,966.70	22,638,979.40
354	Хангамжийн материал	14,130,873.15	20,871,399.52
35410	Бичиг хэргийн материал	77,800.00	381,800.00
35420	Аж ахуйн материал	13,960,083.67	17,770,813.67
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,550,200.00
35460	Хүнсний материал	92,989.48	1,168,585.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>525,970,613.08</u>	<u>536,962,911.39</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	525,970,613.08	536,962,911.39
392	Биет хөрөнгө	514,896,613.08	525,888,911.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	280,849,489.00	330,805,084.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,190,819.86)	(29,054,418.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	201,311,879.00	159,761,679.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,078,353.99)	(47,533,419.89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	125,682,879.08	161,820,669.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,232,472.19)	(65,427,610.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,525,100.80	27,424,830.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,548,410.28)	(14,485,224.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,578,400.00	2,578,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(890,063.48)	(890,063.48)
39217	Ном	888,985.00	888,985.00
393	Биет бус хөрөнгө	11,074,000.00	11,074,000.00
39301	Програм хангамж	430,000.00	430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(430,000.00)	(430,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,074,000.00	11,074,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>554,870,307.93</u>	<u>636,469,553.99</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,781,880.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,781,880.00

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

413	Өглөг	00.00	2,781,880.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,781,880.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>554,870,307.93</u>	<u>633,687,673.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>554,870,307.93</u>	<u>633,687,673.99</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	288,767,215.63	288,767,215.63
512	Хуримтлагдсан үр дүн	145,170,049.19	223,987,415.25
51210	Өмнөх үеийн үр дүн	(89,385,489.21)	145,170,049.19
51220	Тайлант үеийн үр дүн	234,555,538.40	78,817,366.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,933,043.11	120,933,043.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>554,870,307.93</u>	<u>636,469,553.99</u>
		<u>554,870,307.93</u>	<u>636,469,553.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	642,741,965.28	796,862,725.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	255,242,752.28	253,882,356.52
120	Нийтлэг татварын бус орлого	255,242,752.28	253,882,356.52
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	233,422,525.00	32,624,510.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,820,227.28	221,257,846.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,499,213.00	542,980,369.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,607,500.00	331,829,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,607,500.00	331,829,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,278,923.00	160,553,509.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,278,923.00	160,553,509.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,143,300.00	29,901,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,143,300.00	29,901,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	27,469,490.00	20,695,760.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,469,490.00	20,695,760.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	406,388,664.44	681,213,719.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,388,664.44	681,213,719.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,966,590.44	677,231,232.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,168,060.00	293,224,227.37
210101	Үндсэн цалин	178,455,450.29	182,563,787.63
210102	Нэмэгдэл	66,645,409.70	86,679,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,500,000.00	4,335,278.24
210104	Урамшуулал	17,567,200.01	19,646,161.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,295,600.00	39,014,980.95
210201	Тэтгэврийн даатгал	25,439,511.14	28,116,880.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,703,497.53	2,724,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,162,797.99	2,179,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,115.40	544,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,460,677.94	5,449,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,456,926.00	25,526,113.00
210301	Гэрэл, цахилгаан	3,434,557.00	3,627,665.00
210302	Түлш, халаалт	22,022,369.00	21,898,448.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,548,783.00	24,191,309.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,993,476.00
210402	Тээвэр, шатахуун	13,508,020.00	20,155,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,340,763.00	989,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,053,383.00
210408	Бараа материал акталсны зардал	200,000.00	00.00

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	43,406,701.01	234,787,946.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,455,813.51	221,766,722.82
210502	Хоол, хүнс	8,950,887.50	13,021,223.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,365,485.00	6,967,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,121,600.00	6,045,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,979,585.00	322,000.00
210604	Урсгал засвар	1,264,300.00	600,000.00
2107	Томилолт, зочны зардал	499,000.00	309,000.00
210702	Дотоод албан томилолт	499,000.00	309,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	429,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	90,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,797,035.43	53,210,655.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,394,100.00	8,975,229.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,402,935.43	44,235,426.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,422,074.00	3,982,487.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	907,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	907,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,422,074.00	3,075,287.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,422,074.00	3,075,287.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>236,353,300.84</u>	<u>115,649,006.11</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	2,590,270.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	2,590,270.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,797,762.44	39,421,910.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	35,000,000.05
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,797,762.44	4,421,910.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>234,555,538.40</u>	<u>78,817,366.06</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,767,215.63	121,307,932.92	(89,760,379.01)	320,314,769.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	374,889.80	374,889.80
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	288,767,215.63	121,307,932.92	(89,385,489.21)	320,689,659.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	00.00	(374,889.80)	00.00	(374,889.80)
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	234,555,538.40	234,555,538.40
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,767,215.63	120,933,043.11	145,170,049.19	554,870,307.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	288,767,215.63	120,933,043.11	145,170,049.19	554,870,307.93
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	78,817,366.06	78,817,366.06
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,767,215.63	120,933,043.11	223,987,415.25	633,687,673.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	387,499,213.00	491,288,549.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,499,213.00	491,288,549.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,607,500.00	331,829,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,278,923.00	108,861,689.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,278,923.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	108,861,689.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,143,300.00	29,901,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,143,300.00	29,901,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	27,469,490.00	20,695,760.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,469,490.00	20,695,760.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	383,508,623.00	481,184,410.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,508,623.00	481,184,410.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,086,549.00	477,101,123.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,356,500.00	293,224,227.37
210101	Үндсэн цалин	179,643,890.30	182,563,787.63
210102	Нэмэгдэл	66,645,409.70	86,679,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,500,000.00	4,335,278.24
210104	Урамшуулал	17,567,200.00	19,646,161.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,295,600.00	39,014,980.95
210201	Тэтгэврийн даатгал	25,439,511.14	28,116,880.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,703,497.53	2,724,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,162,797.99	2,179,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,115.40	544,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,460,677.94	5,449,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,456,926.00	25,526,113.00
210301	Гэрэл, цахилгаан	3,501,396.00	3,627,665.00
210302	Түлш, халаалт	21,955,530.00	21,898,448.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,348,783.00	24,495,309.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	2,392,876.00
210402	Тээвэр, шатахуун	13,508,020.00	20,148,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,340,763.00	900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,053,983.00
2105	Нормативт зардал	27,800,823.00	76,127,334.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,800,823.00	62,030,514.00
210502	Хоол, хүнс	9,000,000.00	14,096,820.00

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,026,217.00	14,745,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,240,367.00	9,545,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,521,550.00	3,900,000.00
210604	Урсгал засвар	1,264,300.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	499,000.00	309,000.00
210702	Дотоод албан томилолт	499,000.00	309,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,414,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	90,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,888,700.00	3,659,159.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,888,700.00	3,659,159.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,422,074.00	4,083,287.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,422,074.00	3,075,287.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,422,074.00	3,075,287.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,990,590.00</u>	<u>10,104,138.68</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,990,590.00	6,607,550.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,990,590.00	6,607,550.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,990,590.00	6,607,550.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,990,590.00	6,607,550.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,990,590.00)</u>	<u>(6,607,550.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	3,496,588.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,496,588.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	394,489,700.00	377,821,920.00	16,667,780.00	95.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,489,700.00	377,821,920.00	16,667,780.00	95.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,489,700.00	377,821,920.00	16,667,780.00	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,452,800.00	266,794,093.20	5,658,706.80	97.9
210101	Үндсэн цалин	157,598,100.00	156,133,653.46	1,464,446.54	99.1
210102	Нэмэгдэл	86,679,000.00	86,679,000.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	4,335,278.24	200,721.76	95.6
210104	Урамшуулал	23,639,700.00	19,646,161.50	3,993,538.50	83.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,781,300.00	30,584,530.80	6,196,769.20	83.2
210201	Тэтгэврийн даатгал	25,883,200.00	19,686,430.80	6,196,769.20	76.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,724,500.00	2,724,500.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,179,600.00	2,179,600.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	544,900.00	544,900.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,449,100.00	5,449,100.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,601,400.00	25,526,113.00	3,075,287.00	89.2
210301	Гэрэл, цахилгаан	5,464,400.00	3,627,665.00	1,836,735.00	66.4
210302	Түлш, халаалт	22,780,000.00	21,898,448.00	881,552.00	96.1
210303	Цэвэр, бохир ус	357,000.00	00.00	357,000.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,515,000.00	16,968,983.00	546,017.00	96.9
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	13,515,000.00	13,515,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	900,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	1,053,983.00	546,017.00	65.9
2105	Нормативт зардал	23,039,200.00	23,039,200.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,039,200.00	15,039,200.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,700,000.00	7,700,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,900,000.00	3,900,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	309,000.00	1,191,000.00	20.6
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	309,000.00	1,191,000.00	20.6

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	6,900,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	6,900,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	394,489,700.00	382,426,860.00	12,062,840.00	96.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	331,829,700.00	361,731,100.00	(29,901,400.00)	109.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,829,700.00	331,829,700.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,901,400.00	0.00	29,901,400.00	0.0
132001	Орон нутгийн төсвөөс	29,901,400.00	0.00	29,901,400.00	0.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,758,600.00	20,695,760.00	12,062,840.00	63.2
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,758,600.00	20,695,760.00	12,062,840.00	63.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,529,653.00	(1,529,653.00)	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		106,894,753.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ		106,894,753.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		105,886,753.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		26,430,134.17
210101	Үндсэн цалин		26,430,134.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		8,430,450.15
210201	Тэтгэврийн даатгал		8,430,450.15
2104	Хангамж, бараа материалын зардал		7,526,326.00
210401	Бичиг хэрэг		892,876.00
210402	Тээвэр, шатахуун		6,633,450.00
2105	Нормативт зардал		53,088,134.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		46,991,314.00
210502	Хоол, хүнс		6,096,820.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,045,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,045,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		3,366,709.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,366,709.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		108,861,689.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		108,861,689.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		108,861,689.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		1,966,935.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,966,935.68

3. Аудитын ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 26-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

2021 онд Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв нь эх, хүүхдийн эндэгдэл гаргаагүй, 427 иргэнийг хэвтүүлж болон гэрээр эмчилсэн, урьдчилан сэргийлэх үзлэг 6515, гэрийн эргэлт дуудлагаар 55, амбулаториар 2210 иргэнд эмнэлгийг тусламж, сувилгаа хийсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдэж, 1,039.5 мянган 2 төлбөрийн акт тогтоосон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 406,388.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,063.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,438.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль,

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 331,829.7 мянга, ЭМДС-гаас 20,695.8 мянга, орон нутгийн төсвөөс 29,901.4 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 108,861.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 487,792.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 82,580.1 мянга, шилжүүлэн авсан 2,590.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, 40,000.0 мянган төгрөгийн автомашин сумын ЗДТГ-т шилжүүлж, 1,550.2 мянган төгрөгийн хөрөнгө дотоод шилжүүлгээр бараа материал руу шилжүүлэг хийж, 1,784.8 мянган төгрөгийн хөрөнгө актласан байна.

Бараа материалын дансанд хандиваар 171,247.7 мянга, төсвийн хөрөнгөөр 118,788.1 мянга, үндсэн хөрөнгөнөөс 1,550.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 276,167.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 51,691.8 мянган төгрөгийн авлагатай, 2,781.9 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,496.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 44,318.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 536,962.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	3,496.6	3,496.6
Авлага	00.00	51,691.8	51,691.8
Бараа материал	28,899.7	44,318.2	15,418.5
Үндсэн хөрөнгө	525,970.6	536,962.9	10,992.3
Нийт хөрөнгө	554,870.3	636,469.5	81,599.2
Нийт өр төлбөр	00.0	2,781.9	2,781.9
Засгийн газрын хувь оролцоо	554,870.3	633,687.7	78,817.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	554,870.3	636,469.5	81,599.2

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,496.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,496.6 мянган төгрөгөөр өссөн байна.
- Авлага дансны үлдэгдэл 51,691.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 51,691.8 мянган төгрөгөөр өссөн байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 44,318.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 15,418.5 мянган төгрөгөөр өссөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 536,962.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 10,992.3 мянган төгрөгөөр өссөн нь 91,777.9 мянган төгрөгийн хөрөнгө

нэмэгдэж, 43,335.0 мянган төгрөгөөр хасагдаж, 44,235.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 633,687.7 мянган төгрөг болж, 78,817.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 405,982.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 11,492.3 мянган төгрөгөөр бууруулан 394,489.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсөвт тодотгол хийгдээгүй.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 331,829.7 мянга, орон нутгийн төсвөөс 29,901.4 мянга, ЭМДС-гаас 20,695.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 377,821.9 мянган төгрөгийг зарцуулж, 3,075.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 1,529.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 377,821.9 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 108,861.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 26,430.1 мянга, НДШ-н зардалд 8,430.4 мянга, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 46,991.3 мянга, хоол хүнс 6,096.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 16,936.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 3,366.7 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 1,008.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 1,966.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 39,765.7 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, 1,167.7 мянган төгрөгийн хөрөнгө актласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Батлагдсан төсвийн дүн тодорхойгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлээгүй, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн, харилцагчидтай тооцоо нийлсэн болон хөрөнгийн тооллого хийснийг нотлох баримт байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 144 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг байршуулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төсвийн болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 167,454.8 мянган төгрөгийн зөрчилд 17 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 алдаа зөрчилд 2,854.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 34,424.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 308,594.9 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 308,594.9 мянган төгрөгийн 4 алдаа зөрчлийг залруулж, 4 зөвлөмж өглөө.

4.1 Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Хандивын 253,882.3 мянган төгрөгийн орлогыг Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - 1200045 дансанд бүртгэснийг Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө - 120017 дансанд 37,264.4 мянга, Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал -120018 дансанд 216,617.9 мянган төгрөгийг бүртгүүлж,
- Төвлөрүүлэх шилжүүлгийн 3,075.3 мянган төгрөгийг Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэгийн - 213503 дансанд бүртгэснийг Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилтийн - 213403 дансанд бүртгүүлж,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрийг төвлөрүүлэх шилжүүлэгээр тохируулаагүйг,
- ЭМДЕГ-тай тооцоо нийлсэн актаар 51,691.8 мянган төгрөгийн авлагатай гарсныг санхүүгийн тайланд тусгаагүйг тус тус залруулга хийлгэв.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр”, 54.5.2-т “татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт”, 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний

танилцуулга” гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-д заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлж байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 99 нэр төрлийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Эм, боох материал-35130 дансанд эмтэй хамт үнэ төлбөргүй ирсэн нэг удаагийн маск, малгай, улавч, халат, бээлий, хормогч, нүүрний хаалт, гар ариутгагч, зааварчилгаа ном зэргийг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батласан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.16-д “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө.” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Дансны ангилалыг зөв хийх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн хуулийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай

Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд, үнэ зөв, бүрэн мэдээллэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв	8	308,594.9	4	308,594.9					4	0.0
	ДҮН	8	308,594.9	4	308,594.9					4	0.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn